



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (542)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

- *УИХ-ыг сонгох 5 дахь удаагийн сонгуулийн өмнөх улс орны нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулсан мэдээллийн тойм*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Усны экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай*
- *Монгол Улсад зохиогдох олон улсын хэмжээний спортын тэмцээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны тавдугаар сарын 7

№17 (542)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

224. УИХ-ыг сонгох 5 дахь удаагийн сонгуулийн өмнөх улс орны нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулсан мэдээллийн тойм 413

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 225. | Тогтоол хүчингүй болгох тухай                                       | Дугаар 44 | 415 |
| 226. | Хоолны зардлын дундаж норматив батлах тухай                         | Дугаар 45 | 415 |
| 227. | Нэрэмжит тэтгэлгийн журам батлах тухай                              | Дугаар 46 | 416 |
| 228. | Усны экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай                    | Дугаар 47 | 418 |
| 229. | Ажилд томилох тухай   | Дугаар 48 | 419 |
| 230. | Ажлаас чөлөөлөх тухай   | Дугаар 50 | 419 |
| 231. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай                                     | Дугаар 52 | 420 |
| 232. | Хөтөлбөр батлах тухай   | Дугаар 53 | 420 |
| 233. | Хэлэлцээр батлах тухай  | Дугаар 55 | 422 |
| 234. | Орхон аймагт бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах тухай      | Дугаар 56 | 423 |
| 235. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                 | Дугаар 57 | 424 |
| 236. | Ажлаас чөлөөлөх тухай   | Дугаар 58 | 424 |
| 237. | Ажилд томилох тухай   | Дугаар 59 | 424 |
| 238. | Монгол Улсад зохиогдох олон улсын хэмжээний спортын тэмцээний тухай | Дугаар 60 | 425 |
| 239. | Гэрээ байгуулах тухай   | Дугаар 61 | 425 |
| 240. | Төлөвлөгөө батлах тухай   | Дугаар 64 | 425 |
| 241. | Хөтөлбөр батлах тухай   | Дугаар 70 | 429 |
| 242. | Дэд хөтөлбөр батлах тухай   | Дугаар 71 | 433 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

243. Албан тушаалтнуудын 2007 оны хөрөнгө, орлогын байдал 436

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

### УИХ-ЫГ СОНГОХ 5 ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН ӨМНӨХ УЛС ОРНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААР УИХ-ЫН НЭГДСЭН ХУРАЛДААНД ТАНИЛЦУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д улс орны нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар Улсын Их Хурал олон нийтэд мэдээлэхээр заасны дагуу улсын нийгэм, эдийн засаг, Засгийн газрын

санхүүгийн байдлын талаарх үндсэн үзүүлэлтүүдийн түвшинг УИХ дараах байдлаар тоймлон олон нийтэд мэдээлж байна:

1. 2007 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 1642.2 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам 1054.0 мянга, ажиллагсдын тоо 1024.1 мянга,

хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйдчүүд 29.9 мянга болж, ажилгүйдэл 2.8 хувийн түвшинд хүрч, 2004 оныхоос 0.8 пунктээр буурсан байна.

2. Төсвийн байгууллагад ажиллагсдын цалингийн дундаж түвшин 2004 оны эцэст 85.9 мянган төгрөг байсан бол 2008 онд 300.0 мянган төгрөг болж 3.5 дахин нэмэгджээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2004 онд 40.0 мянган төгрөг байсан бол түүнийг шат дараатайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авсны дүнд 2008 онд 108.0 мянган төгрөгт хүрлээ. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 2004 онд 32.0 мянган төгрөг байсан бол 2008 онд 81.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 20.0 мянган төгрөг байсан бол 54.0 мянган төгрөг болж 2.5 - 2.7 дахин нэмэгджээ. Дундаж тэтгэврийн хэмжээ 2004 онд 33.7 мянган төгрөг байсныг 2008 онд 93.0 мянган төгрөгт хүргэж, 2.8 дахин нэмэгдүүлээ. Инфляцийн нөлөөллийг арилгаж тооцооноор 2007 онд 2004 оныхоос нэг ерхийн сарын дундаж бодит мөнгөн орлого 24.3 хувь, үүнээс цалин хөлс 44.0 хувь, тэтгэвэр тэтгэмж 95.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

3. Эдийн засгийн бодит өсөлт 2007 онд 9.9 хувь болж хурдассан. Аж үйлдвэрийн салбарын 2004-2007 оны дундаж өсөлт 9.3 хувь, хөдөө аж ахуйн салбарын дундаж өсөлт 12.4 хувь, барилгын салбарынх 8.5 хувь, тээвэр, холбооны салбарынх 15.2 хувь, худалдааных 6.7 хувь, үйлчилгээний бусад салбарынх 5.0 хувь болжээ. Нэг хүнд ногдох ДНБ-ий (2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн) 2000-2003 оны жилийн дундаж хэмжээ 585.7 мянган төгрөг байсан бол 2004-2007 оны жилийн дундаж хэмжээ 1140.1 мянган төгрөгт хүрч 1.3 дахин нэмэгдсэн байна.

4. Хэрэглээний үнийн индекс 2007 оны эцэст 15.1 хувь бөлжээ. Хэрэглээний үнийн индексийн 2000-2003 оны дундаж 5.6 хувь байсан бол 2004-2007 оных 10.4 хувь болж нэмэгдсэн байна.

5. Төгрөгийн ам. доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байж 2000-2003 онд дунджаар 1108.9 төгрөг, 2004-2007 онд дунджаар 1184.8 төгрөгтэй тэнцэж, энэ хугацаанд 6.8 хувиар суларсан байна. Эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээ 2004-2007 онд жилд дунджаар 36.5 хувиар өсч, 2004 оны эцэст 847.0 тэрбум төгрөг байсан бол 2007 оны эцэст 2401.1 тэрбум төгрөгт хүрчээ. Банкуудаас олгосон зээлийн хэмжээ 2007 оны эцэст 2056.0 тэрбум төгрөгт хүрч, 2004 оны эцэстэй харьцуулахад 3.4 дахин өсчээ. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин 2004 оны эцэст 6.4 хувь байсан бол 2007 оны эцэст 3.3 хувь болж буурчээ.

6. Улсын төсвөөс 2000-2003 онд 146.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2004-2007 онд 617.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх 4 жилийнхээс 4.2 дахин нэмэгджээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2000-2003 онд 593.5 сая ам. доллар байсан бол 2004-2007 онд 1380.4 сая ам. доллар болж, 2.3 дахин өссөн байна. Боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ байнга өссөөр байна. Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгийн тоо 2004-2007 онд дунджаар 734 болж 2000-2003 оныхоос 10.3 хувиар, тэдгээрт хүмүүжиж буй хүүхдийн тоо 2004-2007 онд дунджаар 92.3 мянга болж 2000-2003 оныхоос 6.3 хувиар тус тус өссөн байна. Ерөнхий боловсролын сургуулийн тоо 2007-2008 оны хичээлийн жилд 754 болж 2004 оныхоос 44-өөр нэмэгдэв. Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 2004 онд 87.1 хувь байсан бол 2007 онд 93.7 хувь, бага боловсролын хамран сургалт 2004 онд 89.8 хувьтай байсан бол 2007 онд 93.5 хувь болсон байна. Эрүүл мэндийн салбарын хувьд 2004-2007 онд 100,000 төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2000-2003 оны дундаж түвшингөөс 38.4 хувиар, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдох нялхсын эндэгдэл 43.6 хувиар тус тус буурсан байна. Орон сууцны фонд 2000-2003 онд дунджаар 6649.7 мянган квадрат метр байсан бол 2004-2007 онд дунджаар 7586.5 мянган квадрат метр болж 14.1 хувиар нэмэгдлээ. Орон сууцны фонд 2007 онд 8105.1 мянган квадрат метр болж 2004 оныхоос 977.7 мянган квадрат метр буюу 13.7 хувиар нэмэгдсэн байна.

7. Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөц 2004 онд 163.6 сая ам. доллар байсан бол 2007 оны эцэст 975.3 сая ам. доллар болж, 5.9 дахин нэмэгджээ. Гадаад валютын цэвэр албан нөөц импортын долоо хоноогоор 2004 онд 8.3 долоо хоногийн импортын хэрэгцээг хангахуйц хэмжээнд байсан бол 2007 оны эцэсийн байдлаар 24 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц нөөцийг бүрдүүлсэн байна. Төсвийн үндсэн үзүүлэлтүүд сайжирч, ДНБ-д эзлэх төсвийн нийт алдагдал 2000-2003 онд дунджаар -5.6 хувь байсан бол 2004-2007 онд дунджаар 1.8 хувийн ашигтай болж, төсвийн нийт тэнцэл сайжирлаа.

8. Гадаад худалдааны нийт эргэлт 2000-2003 онд жилд дунджаар 7.2 хувиар, 2004-2007 онд жилд дунджаар 29.6 хувиар тус тус өсч, гадаад худалдааны нийт эргэлтийн дундаж өсөлт сүүлийн 4 жилд өмнөх 4 жилийнхээс 4.1 дахин нэмэгдэж, гадаад худалдаа бүхэлдээ идэрхжсэн байна. Үүний зэрэгцээ Монгол улсын төлбөрийн нийт тэнцэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр 240.7 сая

ам.долларын ашигтай гарч байна. Монгол улсын гадаад өрийн үлдэгдэл 2007 оны эцэст 1.5 тэрбум ам.доллар байна. Гадаад зээлийн өрийн үлдэгдлийн 64.0 хувийг олон улсын санхүүгийн байгууллагад төлөх төлбөр эзэлж байгаа бол үлдсэн 36.0 хувийг хандивлагч орнуудад төлөх төлбөр эзэлж байна. Гадаад өрийн үлдэгдлийн хэмжээг олон улсын төвшинд тооцдог аргачлалаар авч үзэхэд сэрэмжлүүлэх түвшингөөс доогуур байна.

9. 2008 онд Монгол улсын нэгдсэн төсвийн нийт орлого болон тусламжийн орлого 2 423.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2.560.1 тэрбум төгрөг, төсвийн урсгал тэнцлийн ашиг 653.8 тэрбум төгрөг, төсвийн нийт тэнцлийн алдагдалын ДНБ-д эзлэх хувь -2.5 хувь байхаар хуульчилсан төлөвлөгөөт зорилтууд биелэгдэх төлөвтэй байна.

10. Санхүүгийн төлөвт тусгагдаагүй боловч Засгийн газрын урьд гаргасан шийдвэрийн улмаас гарч болзошгүй өр төлбөр, нэмэлт зардал, орлогын дутагдал гарахааргүй төлөвтэй байна. Харин одоогийн байдлаар дэлхийн зах зээл дээрх хүнсний зарим бүтээгдэхүүн, газрын тосны үнийн өсөлтөөс хамаарч аж ахуйн нэгжүүдийн зардал өсч, улмаар улсын төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого буурах, түүнчлэн орон сууцны салбарт Засгийн газрын бондын арилжаагаар орж ирэх хөрөнгийн эргэн төлөлт муудах, олон улсын зах зээлд Засгийн газрын бонд гаргаж 1.2 тэрбум ам.долларын эх үүсвэр төвлөрүүлэхэд ханш, хүүгийн зөрүүнээс үүдэн гарах алдагдал, 2007 оны хөрөнгө оруулалтын зарим санхүүжилт он дамжсантай холбогдож, 2008 оны төсвийн санхүүжилтэд нэмэлт ачаалал гарч болзошгүй зэргийг анхаарах шаардлагатай байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болгох тухай

Шуудангийн тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Дүрэм, журам батлах тухай" Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн

34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Р.РАШ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### Хоолны зардлын дундаж норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 868 (найман зуун жаран найман) төгрөгөөр тогтоосугай.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдийн өдрийн хоолны зардлын улсын төсвөөс олгох хэмжээг 329 (гурван зуун хорин есөн) төгрөгөөр, 24 цагийн цэцэрлэгийн хүүхдийн хоногийн хоолны зардлын улсын төсвөөс олгох хэмжээг 493 төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны зардлыг өдөрт 400 төгрөгөөр тогтоосугай.

4. Хоолны зардлын болон үдийн цайны шинэчилсэн нормативыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

5. Нэг хүүхэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг нь тооцож байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

6. Хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага,

орчны ариун цэвэрт тогтмол хяналт тавьж ажиллахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Ц.Шийрэвдамбад даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 167 дугаар тогтоол, "Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай" Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 16-ны

өдрийн 194 дүгээр тогтоолуудын 2, 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Н.БОЛОРМАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 02 дугаар  
сарын 06-ны өдөр**

**Дугаар 46**

**Улаанбаатар  
хот**

### Нэрэмжит тэтгэлгийн журам батлах тухай

Боловсролын тухай хуулийн 43.2.9, Дээд боловсролын тухай хуулийн 19.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ыг нэгдүгээр, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг"-ийн загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталж, нэрэмжит тэтгэлгийг 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаанд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Н.БОЛОРМАА**

**Засгийн газрын 2008 оны 46 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт**

### СУРЛАГА, СПОРТ, УРЛАГИЙН ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН СУРАЛЦАГЧДАД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

#### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Онцгой авъяас, чадварыг хөгжүүлэх, урамшуулан дэмжих зорилгоор сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв (цаашид "сургууль" гэнэ)-ийн суралцагч, оюутан, магистрант, докторант (цаашид "суралцагч" гэнэ)-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг (цаашид "тэтгэлэг" гэнэ) олгоход энэ журмыг баримтална.

1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт гурваас доошгүй голч дүнтэй суралцаж байгаа дараахь болзлыг хангасан суралцагч нэр дэвшинэ:

1.2.1. Техник, технологийн чиглэлээр зохион байгуулагдсан дэлхий, тив болон олон улсын уралдаан, тэмцээнд эхний гурван байрын аль нэгийг эзэлсэн;

1.2.2. Дэлхийн оюутны спортын их наадам, Дэлхийн болон Тивийн оюутны аварга шалгаруулах тэмцээнд тус тус эхний гурван байрын аль нэгийг эзэлсэн, Монголын оюутны спортын их наадам, Монголын оюутны аварга шалгаруулах тэмцээнд тус тус тэргүүн байр эзэлсэн;

1.2.3. Сургуулиудын нэгдсэн эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, эхний гурван байрын аль нэгийг эзэлсэн оюутан, мэргэжлийн сэтгүүлд хоёроос доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн, олон улсын эрдэм шинжилгээний хуралд шалгарч илтгэл тавьсан, улс орны хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний бүтээл туурвисан магистрант, докторант;

1.2.4. Олон улсын хэмжээний мэргэжлийн соёл, урлагийн уралдаан, наадамд эхний гурван байрын аль нэгийг эзэлсэн, улсын хэмжээний



мэргэжлийн соёл, урлагийн их наадам, уралдаан, тэмцээнд тэргүүн байр эзэлсэн суралцагч.

1.3. Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын мэргэжлийн чиглэлээр 4 улирал дараалан 3.8-аас доошгүй голч дүнтэй суралцсан, олон нийтийн ажилд идэвхи санаачилгатай оролцдог, хамт оныхоо дунд нэр хүндтэй, сургуулийнхаа шилдэг оюутнаар шалгарсан суралцагч нэр дэвшинэ.

1.4. Тэтгэлгийн болзол хангасан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын гарын үсэг бүхий өргөмжлөл, мөнгөн шагналыг 10 сарын хугацаагаар олгоно.

1.5. Жил бүр 30 хүртэл суралцагчид сар бүрийн 100.000 төгрөгийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг, 50 хүртэл суралцагчид сар бүрийн 80.000 төгрөгийн Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг тус тус олгоно.

## Хоёр. Бүртгэл, шалгаруулалт

2.1. Энэхүү журмын 1.2, 1.3-т заасан болзлыг хангасан суралцагч өөрөө буюу сургууль, оюутны байгууллага нь тухайн суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлж болно.

2.1.1. Тэтгэлэгт нэр дэвшигч нь дор дурдсан баримт бичгийг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор суралцаж байгаа сургуулийнхаа захиргаанд өгнө.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг (загварын дагуу);

-Сургалтын албаар баталгаажуулсан сурлагын болон голч дүнгийн тодорхойлолт;

-Энэхүү журмын 1.2-т заасан болзлыг хангасан суралцагч нь медаль, шагнал, өргөмжлөл, гэрчилгээний болон тухайн арга хэмжээг зохион байгуулсан байгууллагын шийдвэрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, монгол хэл рүү хөрвүүлсэн албан ёсны орчуулга;

-Энэхүү журмын 1.3-т заасан болзлыг хангасан суралцагч нь сургуулийн захиргаа болон оюутны холбооны тодорхойлолт.

## 2.2. Сургуулийн захиргаа нь сургалтын

алба, багш, оюутны байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан нэр дэвшигчдийн бичиг баримтыг нэг бүрчлэн шалгаж, хүн тус бүр дээр дүгнэлт гаргана. Энэ дүгнэлтийг үндэслэн их сургууль 6 (зургаа) хүртэл, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт- үйлдвэрлэлийн төв 3 (гурав) хүртэл суралцагчийг ил тод зарчмаар урьдчилан шалгаруулж, тэнцсэн суралцагчийн бичиг баримтыг ажлын хэсгийн дүгнэлтийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор захирлын албан бичгээр боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид "яам" гэнэ)-д хүргүүлнэ.

2.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сургуулиудаас ирүүлсэн нэр дэвшигчдийн баримт бичгийг журамд нийцсэн эсэхийг хянан үзэж жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь ирүүлсэн баримт бичгийг холбогдох журмын дагуу судлан үзэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад танилцуулан тэтгэлэг олгох асуудлыг эцэслэн шийдвэрлэж, сургуулиудад мэдэгдэнэ.

## Гурав. Бусад зүйл

3.1. Тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн талаархи танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын вэб сайтад байршуулна.

3.2. Тэтгэлэгтэй суралцагч нь болзол хангасан бол дахин нэр дэвших эрхтэй.

3.3. Олон улсын хэмжээний спорт, урлагийн арга хэмжээнд амжилттай оролцож, холбогдох журмын дагуу Засгийн газраас мөнгөн шагнал авсан суралцагчдад тэтгэлэг давхардуулан олгохгүй.

3.4. Тэтгэлэг хүлээн авагч нь худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, сургуулиас хасагдсан, чөлөө авсан тохиолдолд тэтгэлгийг зогсооно.

3.5. Шалгаруулалтын явцад гарсан маргааныг холбогдох хяналтын байгууллага хянан шийдвэрлэнэ.

\*Үүнд Монгол Улсын Засгийн газрын 2005.07.14-ний 165 дугаар тогтоол  
2007.08.22-ны 208 дугаар тогтоол  
2007.06.20-ны 147 дугаар тогтоолоор баталсан журмууд хамрагдана.

Засгийн газрын 2008 оны 46 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**"МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН ЕРӨНХИЙ  
САЙДЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ НЭР ДЭВШИГЧИЙН  
МЭДҮҮЛЭГ"-ИЙН ЗАГВАР**

1. Овог .....
2. Эцэг /эх/-ийн нэр.....
3. Төрсөн он, сар, өдөр, газар .....
4. Иргэний үнэмлэх, регистрийн дугаар .....
5. Оршин суугаа хаяг .....
6. Утас, и-мэйл .....
7. Суралцаж байгаа сургууль, анги, мэргэжил, түвшин, голч дүн .....
8. Олон нийтийн сонгуульт ажил .....
9. Тэтгэлэгт нэр дэвших үндэслэл .....
10. Нэр дэвшиж байгаа тэтгэлгийн нэр .....
11. Өөр тэтгэлэг, тусламж, зээл, мөнгөн шагнал авч байгаа эсэх .....
12. Харилцах банкны нэр, дансны дугаар .....

Зураг  
2x3

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Он, сар, өдөр)

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2008 оны 02 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

**Усны экологи, эдийн засгийн  
үнэлгээ батлах тухай**

Усны тухай хуулийн 10.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ"-г хавсралтын ёсоор баталсугай.

2. Усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, учирсан хохирлыг үнэлэх, ус ашиглагч, түгээгч, хэрэглэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлоход усны экологи-эдийн засгийн

үнэлгээг мөрдөж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Улсын мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД**

**Г.ШИЙЛЭГДАМБА**

Засгийн газрын 2008 оны 47 дугаар  
тогтоолын хавсралт

## МОНГОЛ ОРНЫ УСНЫ ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

(мянган төг, шоо метр)

д/д	Монгол орны усны сав газар	Гадаргын ус	Газрын доорхи ус
1	Хойд мөсөн далайн ай сав		
	1.1 Сэлэнгийн сав газар	50.0	20.0
	1.2 Хөвсгөл нуур, Орхон, Хараа, Ерөө, Эгийн голын сав газар	30.0	20.0
	1.3 Туул голын сав газар	100.0	50.0
2	Номхон далайн ай сав		
	2.1. Онон, Улз, Халх, Хэрлэн голын сав газар	50.0	20.0
3	Төв Азийн гадагш урсацгүй ай сав		
	3.1. Говь-Алтай, Хангайн нурууны өмнөд хэсгийн жижиг голуудын сав газар	150.0	20.0
	3.2. Алтайн нурууны өврийн голуудын сав газар	100.0	20.0
	3.3. Их нууруудын хотгорын сав газар	30.0	10.0

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

Ажилд томилох тухай

Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын гаалийн ерөнхий газрын дэд даргаар тус тус түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Дашийн Оюунчимэг, Нарантунгалагийн Болд нарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

Ажлаас чөлөөлөх тухай

Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ерөнхий газрын дэд даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Нанзадын Чулуунбаатар, Догсомын Батцогт нарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Улсын гаалийн

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын 2008 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 230 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "...6 хувь ..." гэснийг "...4 хувь..." гэж өөрчилсүгэй.

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

2. Энэ тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хэвлэлийн үйлдвэрлэл" хөтөлбөрийг хэвсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа нарт даалгасугай.

Хөтөлбөр батлах тухай

3. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан салбарын мэргэжлийн холбоо, холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулж, биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Х.НАРАНХҮҮ

Засгийн газрын 2008 оны 53 дугаар тогтоолын хэвсрэлт

### "ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ" ХӨТӨЛБӨР

**Нэг. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал**

1. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод 200 гаруй, орон нутагт 20 гаруй аж ахуйн нэгж хэвлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Статистикийн мэдээгээр 2006 оны байдлаар хэвлэл, цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 1 хувийг эзэлж байна. Дотоодын хэвлэлийн бүтээгдэхүүний хэрэглээний 40 орчим хувь буюу жилдээ 20 гаруй тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн гадаадад захиалгаар хэвлэгдэж, цаашид улам өсөх хандлагатай байна. Хэвлэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүхий эд материал нь импортоос шууд хамааралтай.

2. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт 4000 орчим хүн ажиллаж байгаа ба тэдний чадавхи, сургалтын тогтолцоог сайжруулах нь тулгамдсан

асуудлын нэг болоод байна. Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого тодорхойгүй, мэргэжлийн боловсон хүчний хангамж дутагдалтай байна. Улаанбаатар хотод төвлөрч байгаа хэвлэлийн үйлдвэрүүдийг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах, эдийн засаг, санхүүгийн чадавхитай болгох арга хэмжээ үгүйлэгдэж байгаа юм.

**Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

3. Дотоодын хэвлэлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлд орчин үеийн үндсэн, туслах материал болон дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх нь чухал байна. Хэвлэлийн үйлдвэрлэлд дэлхийн хөгжлийн хандлага болсон тоонд суурилсан "хэрэгцээ дагасан хэвлэл" технологийг нэвтрүүлэх шаардлага гарч байна. Сүүлийн жилүүдэд хэвлэмэл бүтээгдэхүүний дотоод зах зээлийн эрэлт

хэрэгцээ эрчимтэй өсч байгаатай холбогдуулан: үндэсний хэвлэлийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа

4. Хөтөлбөрийн зорилго нь хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэхэд оршино.

5. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхээр дараахь зорилтыг дэвшүүлж байна:

5.1. Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

5.2. Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоод үйлдвэрлэлийг өргөжүүлэх;

5.3. Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх;

5.4. Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;

5.5. Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах.

6. Хөтөлбөрийн 5.1 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.1. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж боловсруулах;

6.2. Үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний стандарт, техникийн нөхцөлийг боловсруулах, шинэчлэн батлуулах;

6.3. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх.

7. Хөтөлбөрийн 5.2 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.1. Дотоодын түүхий эдэд түшиглэн цаасны үйлдвэр байгуулах судалгаа хийж техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах;

7.2. Хэвлэлийн үйлдвэрлэлд өргөн хэрэглэгддэг үндсэн болон туслах материалын үйлдвэр байгуулах төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах;

7.3. Байгаль орчинд халгүй, дэлхийн жишигт нийцсэн сав, баглаа боодол, шошгоны үйлдвэрийг байгуулахад техникийн тусламж үзүүлэх санхүүжүүлэгчийг олох;

7.4. Бага оврын хэвлэлийн техник, сэлбэг хэрэгслийн үйлдвэрийг бүсийн төвүүдэд байгуулах.

8. Хөтөлбөрийн 5.3 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1. Хэвлэлийн техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх;

8.2. Хэвлэлийн үйлдвэрийн технологийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;

8.3. Хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтын лаборатори байгуулах;

8.4. Техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох;

8.5. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт технологийг нутагшуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авч хөнгөлөлттэй зээлд хамруулах.

9. Хөтөлбөрийн 5.4 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1. Ном, хэвлэлийн бүтээгдэхүүн, түүхий эд, материалыг орон нутагт хүргэх, түгээх сүлжээг байгуулах;

9.2. Хэвлэлийн үйлдвэрлэл орон нутагт шинээр байгуулах, технологийн шинэчлэл хийх төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах.

10. Хөтөлбөрийн 5.5 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

10.1. Хэвлэлийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх;

10.2. Салбарын ажил, мэргэжлийн ангилал, мэргэжлийн үндсэн норматив, хөдөлмөрийн тарифыг шинэчлэн боловсруулах;

10.3. Хэвлэлийн үйлдвэрийн удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх зорилгоор сургалт зохион байгуулж, үйлдвэр түшиглэсэн дадлагын төвийг ажиллуулах.

**Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, зарчим**

11. Хөтөлбөрийг 2008-2016 онд дараахь үе шатаар хэрэгжүүлнэ:

11.1. Нэгдүгээр үе шат. 2008–2010 онд:

- а/үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн орчин болон стандартыг шинэчлэн бүрдүүлэх;
- б/үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэж, техник, технологийн шинэчлэлийг эхлүүлэх;
- в/дотоодын зах зээлд салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх;

11.2. Хоёрдугаар үе шат. 2011-2016 онд:

- а/үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, дотоод зах зээлд эзлэх байр суурийг өсгөн бататгах;
- б/орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- в/салбарын үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

12. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь салбарын мэргэжлийн холбоо, түүний гишүүд, төрийн бус байгууллага, төрийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд тулгуурлах явдал юм.

**Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт**

13. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Үйлдвэр, худалдааны яам хэрэгжүүлнэ. Үйлдвэр, худалдааны яам нь Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо болон хувийн хэвшлийн оролцоотойгоор жил бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган түүнийг зохион байгуулна.

14. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох яам, байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодоос жил бүрийн II, IV улиралд Үйлдвэр, худалдааны яам авч нэгтгэн дүгнэж жилийн дүнг Засгийн газарт тайлагнаж байна.

**Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт**

15. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

- 15.1. аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө оруулалт;
- 15.2. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих болон хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгө;
- 15.3. олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл;
- 15.4. дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалт.

**Долоо. Шалгуур үзүүлэлт**

16. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

- 16.1. Эрх зүйн орчин болон стандартын байдалд хөндлөнгийн шинжээчийн хийсэн үнэлгээ, дүгнэлт;
- 16.2. Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүд;
- 16.3. Шинэ техник, технологи, инноваци нэвтэрсэн байдал;
- 16.4. Ажлын байрны өсөлт, бууралт, зорилтот сургалтын тоо, түүнд хамрагдсан хүний тоо;
- 16.5. Хэрэглэгчийн үнэлгээ (санал асуулгаар).

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Хэлэлцээр батлах тухай**

"Олон улсын гэрээний тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Доха хотноо гарын үсэг зурсан "Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын Эдийн

засаг, худалдаа, техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД**

**Х.НАРАНХҮҮ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2008 оны 02 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 56

 Улаанбаатар  
хот

 Орхон аймагт Бүсийн оношилгоо,  
эмчилгээний төв байгуулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

байгуулж, төвийн үйлчлэх хүрээнд хамаарах аймаг, сумыг хавсралтын ёсоор баталсугай.

Орхон аймгийн нэгдсэн эмнэлгийн хүний нөөц, материаллаг баазад тулгуурлан Бүсийн оношилгоо, эмчилгээний төв

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

 ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

 Засгийн газрын 2008 оны 56 дугаар  
тогтоолын хавсралт

### ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНД ХАМААРАХ АЙМАГ, СУМ

Д/д	Аймгийн нэр	Сумдын нэр
1	Булган	Баян-Агт
		Бугат
		Бүрэгхангай
		Гурванбулаг
		Дашинчилэн
		Могод
		Орхон
		Сайхан
		Сэлэнгэ
		Тэшиг
		Хангал
		Хишиг-Өндөр
		Хутаг-Өндөр
		Булган
Баяннуур		
2	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ
		Арбулаг
		Баянзүрх
		Бүрэнтогтох
		Галт
		Жаргалант
		Их-Уул
		Рашаант
		Рэнчинлхүмбэ
		Тариалан
		Тосонцэнгэл
		Төмөрбулаг
		Түнэл
		Улаан-Уул
		Ханх
		Цагаан-Уул
		Цагаан-Үүр
		Цэцэрлэг
Чандмань-Өндөр		
Шинэ-Идэр		
Мөрөн		
Эрдэнэбулган		
Цагааннуур		
3	Сэлэнгэ	Баруунбүрэн
		Орхонтуул
4	Орхон	Баян-Өндөр
		Жаргалант

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

Дарга - Түлш, эрчим хүчний сайд

нь:

1. "Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 117 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 27-30 дахь заалт нэмсүгэй;

30. Монгол Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга - Байгаль орчны сайд

27. Монгол-Кувейтийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

2. Мен хавсралтын 14 дэх заалтын "Дарга - онцгой байдлын асуудал хариуцсан сайд" гэснийг "Дарга - Хүнс, хөдөө аж ахуйн сайд" гэж өөрчилсүгэй.

Дарга - Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 117 дугаар тогтоолын хавсралтын 16 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

28. Монгол-Катарын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга - Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

29. Монгол Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

С.ОЮУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Мажигийн Тунгалагийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Даржаагийн Нямжавыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргаар түр

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Азийн оюутны аварга шалгаруулах ширээний теннисийн анхдугаар болон түүн Азийн волейболын аварга шалгаруулах тэмцээнийг 2008 онд Монгол Улсад зохион байгуулахаар тогтсугай.

2. Дээрх тэмцээнийг зохион байгуулах хороог байгуулан ажиллуулах бэлтгэлийг бүрэн

Монгол Улсад зохиогдох олон улсын хэмжээний спортын тэмцээний тухай

хангуулсны үндсэн дээр тэмцээнийг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэндэ даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Багш сурган хүмүүжүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ерөнхий боловсролын тогтолцоог шинэчлэх чиглэлээр Монголын багш нарын холбоо болон Ахмад багш нарын холбоонд; гадаадад байгаа Монголын соёлын өвийг хамгаалах, түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх, мэдээлэл цуглуулах, Монгол судлаач эрдэмтдийг дэмжин монгол судлалыг хөгжүүлж, хамтран ажиллах чиглэлээр "Монголын соёлын өв" олон улсын нийгэмлэг,

Гэрээ байгуулах тухай

Монгол судлалын олон улсын холбоонд, үндэсний урлаг, түүх соёлын бүтээлийг гадаадад сурталчлах, урлаг соёлын хөгжилд иргэдийн оролцоог дэмжих чиглэлээр Монголын Урлагийн зөвлөлд зарим чиг үүргээ хариуцуулан гүйцэтгүүлэхээр тус тус гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Н.БОЛОРМАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын тусгай сангийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх, гадаад орон, олон улсын байгууллагад санал болгох замаар шийдвэрлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн

Төлөвлөгөө батлах тухай

сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөний биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Х.НАРАНХҮҮ

Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолын хавсралт

## НООЛУУРЫН САЛБАРТ 2012 ОН ХҮРТЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардлагатай хөрөнгө (сая төгрөг)					Хэрэглэлийг зохицуулах, хяналт тавих байгууллага
				2008	2009	2010	2011	Эх үүсвэр	
1	I. Хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд 1. Дэлхийн худалдааны байгууллагын өмнө Монгол Улсын хүлээсэн Урэг амлалтын хүрээнд бохир ноолуурын экспортын татварыг шинэчлэн тогтоох тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх 2. Үйлдвэрлэл технологийн паркын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх арга хэмжээ авах 3. Дотоодод үйлдвэрлэж байгаа ноолуурын утас, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнтэй ижил нэрийн барааны импортын татварыг нэмэгдүүлэх асуудлыг судалж боловсруулах 1. Түүхий эдийг бэрхээр дамжуулан худалдаалах механизмыг бүрдүүлэх 2. Олон улсын болон Монгол Улсын стандартын шаардлага хангасан боловсруулалт хийсэн түүхий эдийг экспортлох механизмыг бүрдүүлэх 3. Түүхий эдийн экспортод тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах, хууль бус экспортыг зогсоох	2008	-	-	-	-	УХЯ МННХ		
		2008	-	-	-	-	УХЯ		
		2008	-	-	-	-	УХЯ МННХ		
2	Түүхий эд болгалийн тогтолцоог боловсронгуй болгох, зах зээлийн зарчмд нийцсэн түүхий эдийн бирж байгуулах эрх зүйн үндэс боловсруулах	2008-2009	12.0	10.0	10.0	10.0	Зээл, тусламж		
		2008-2009	-	-	-	-	УХЯ УТЕГ МННХ		
3	II. Эрэх нэхэх, сүлжмэл хучин чадлыг нэмэгдүүлэн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулж, эцсийн болон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн өргөжүүлэн замаар ноолуур боловсруулах чиглэлээр буюу аж үйлдвэрийн парк байгуулах зорилтын хүрээнд 1. Түүхий эдийн нөөцтэй үлдэцлэн бийрхэн ноолуур, эрэх, сүлжмэл нэхэх шат дамжлагыг өргөтгөх үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлэх 2. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	2008-2011	10.0	10.0	10.0	10.0	Төсвийн болон үйлдвэрийн зардал	УХЯ УТЕГ УММГ МННХ	
		2008-2011	57000.0	40500.0	20000.0	20000.0	Хөрөнгө оруулалт, зээл, тусламж	УХЯ СЯ МННХ	

№	Төрлийн нэр, загвар, сайжруулж нэр төрлийг олшруулах, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд	2008-2011	250.0	120.0	-	Хөрөнгө оруулалт, эзэл, тусламж	ҮХЯ СЯ МННХ
2	Ноолуур үйлдвэрлэлийн цогцолбор болгон мөхүүж болон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах	2008-2010	-	-	-	-	ҮХЯ СЯ
3	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудад түүхий эдийн бэлтгэлд нь зориулан олох хөнгөлөлттэй зээлийн сан бий болгох асуудлыг судлах	2008-2009	-	-	-	-	ҮХЯ СЯ МННХ
4	Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад туслах материалыг импортлох үйл ажиллагааг эдийн засгийн аргаар дэмжих	2008-2009	-	-	-	-	ҮХЯ СЯ МННХ
5	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг татварт бүрэн хамруулах	2008	-	-	-	-	ҮХЯ СЯ МННХ
6	Салбарын хүний нөөцийн чадварийг дээшлүүлэх	2008-2012	-	-	-	-	ҮХЯ БСШУЯ
7	III. Бүтээгдэхүүний чанар, загварыг сайжруулж нэр төрлийг олшруулах, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд	2008-2012	-	100.0	100.0	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөв	ҮХЯ НХХЯ СЯ МННХ
8	Ноолуур боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх	2008-2009	-	-	-	-	ҮХЯ МННХ
8	Шалдлагатай үндэсний стандартуудыг боловсруулах	2008-2012	-	-	-	-	ҮХЯ МННХ

9	Эрдэм шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	1.Нэхмэлийн хүрээлэнгийн лабораторийг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр ик бүрэн шинэчлэх арга хэмжээ авах	2008-2009	200.0	200.0	200.0	200.0	200.0	Зээл, тусламж	УХЯ СЯ
10	Ноолуурын салбарын өрсөлдөх чадварын судалгаа	1. Салбарын өрсөлдөх чадварыг тодорхойлох өрсөлдөгч орнуудтай харьцуулсан судалгаа хийж байх 2. Ноолуурын зах зээл, хэрэглэгч, бүтээгдэхүүний нийлүүлэлт болон гадаадын өрсөлдөгчийн судалгааг тогтмол хийж байх	2008-2012	-	-	-	-	-	-	УХЯ
11	Оны шилдэг загвар, бүтээгдэхүүн, загвар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шалгаруулж урамшуулах	1. Оны шилдэг загвар, бүтээгдэхүүн, загвар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шалгаруулах ажлыг зохион байгуулах 2. Экологийн цэвэр, чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөлгөөнийг өрнүүлэх	2008-2011	-	-	-	-	-	-	МННХ УХЯ
12	Олон улсын зах зээлд монгол ноолуурын чанарыг таниулах чанарын шаардлага хангасан монгол "брэнд" бүтээгдэхүүний бий болгох	1.Олон улсын борлуулалтын сүлжээний шаардлагад нийцсэн "брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бий болгох 2. Монгол ноолууран бүтээгдэхүүнийг сурталчлах, чанарын тэмдэгтэй болгох зорилго бүхий үйл ажиллагааг гадаадын мөргэжлийн байгууллагуудын орлоцотойгоор хэрэгжүүлэх 3. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг олон улсын стандарт (ISO)-ын шаардлага хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах	2008-2012	50.0	70.0	70.0	70.0	70.0	Зээл, тусламж	УХЯ СЯ МННХ МУХАУТ
13	Ямаан сүргийн бүтцийг оновчтой болгох, ноолуурын чанарыг сайжруулах	1. Сүргийн бүтэц, ноолуурын чанарыг сайжруулах арга хэмжээг малын чанар, үржлийн ажлыг сайжруулах чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хүрээнд хэрэгжүүлэх 2. Ямаанд зориулалтын будааг тэмдэглэгээг тавихыг дэмжих	2008-2011	200.0	200.0	100.0	20490.0	20370.0	Зээл, тусламж	ХХААЯ УХЯ МННХ  ХХААЯ УХЯ МННХ
		IV. Түүхий эрдийн чанарыг сайжруулах, бэлтгэлийн системийг боловсронгуй болгох хүрээнд		57722.0	41210.0	20490.0				
		ДҮН Тайлбар. МННХ – Монголын ноос ноолуурын холбоо								

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Тариалангийн тухай хуулийн 4.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийн 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын ёсоор, уг хөтөлбөрийг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2008 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг үүрэг болгосугай.

4. Орон нутгийнхаа онцлогт тохируулан "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, дүнг нь жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД

Ц.ГАНХУЯГ

Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

### "АТРЫН ГУРАВ ДАХЬ АЯН"-ТАРИАЛАНГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Газар тариалангийн салбарын оноогийн байдал

1. Монгол Улс 1959 онд атрын анхны, 1976 онд 2 дахь аяныг амжилттай зохион байгуулсны үр дүнд тариалангийн эргэлтийн талбайн хэмжээ 1.2 сая га-д хүрч үр тариа, төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрч тариалангийн хөгжлийн шинэ үеийг тавьсан билээ. Харин сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын нөлөө ихэссэн, тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө санхүүгийн чадавхи суларсан, мэргэшсэн ажилтан, мэргэжилтний тоо цөөрсөн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж тариалангийн нийт бүртгэгдсэн талбайн 30 хувийг ашиглаж, хэрэгцээт буудайн 24.9 хувь, хүнсний ногооны 47.0 хувь, төмсний 86.0 хувийг тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Газар тариалангийн техникийн парк хуучирч, үйлдвэрлэлд ашиглаж байгаа трактор, комбайны тоо цөөрч, 2008 оны эхний байдлаар улсын хэмжээнд 701 трактор, 486 комбайн, 1500 үрлүүр байна. Эдгээрийг техникийн хүч чадлаар нь тооцоход 170.0-175.0 мянган га талбайд тариалалт хийж, ургацыг нь хурааж, мөн хэмжээний талбайд уриач бэлтгэх боломжтой байна. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн боломж

хязгаарлагдмал байгаагаас эрдэс бордоо, ургамал хамгааллын бодис хэрэглэх нь эрс багасч тариалангийн талбайн хог ургамал нэмэгдэж, өвчин хортон тархах, хөрсний үржил шим доройтох зэрэг сөрөг үзэгдлүүд бий болсон нь гангийн эрсдэлийн зэрэгцээ газар тариалангийн бүтээгдэхүүний бүтээмж, чанарыг бууруулах үндсэн шалтгаан болсоор байна. Олон улсын зах зээл дээр газрын тосны үнэ өссөнөөр эрчим хүчний хомсдол үүсч улмаар хөгжингүй орнуудад таримлаас био түлш үйлдвэрлэх болсон, уур амьсгалын хэт дулаарлаас үүдэн буудай экспортлогч зарим улс ургац алдаж ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ өсч байна.

#### Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага

2. Дэлхийн зах зээл дээр гурил, буудайны эрэлт хэрэгцээ нэмэгдэж үнэ нь жилээс жилд өсөж байгаагийн зэрэгцээ байгалийн гаралтай цэвэр, аюулгүй хүнс хэрэглэх сонирхол давамгайлах болсон өнөө үед нөөц бололцоогоо дайчлан үр дүнтэй ашиглаж, өмнөх жилүүдийн туршлага, сургамжаа орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн ашиглах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх шаардлага бий болсон байна.



Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого болон Эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд газар тариалангийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх тодорхой ажлууд хийх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас 2008 оныг "Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил" болгон зарласан ажлын хүрээнд дотоодын улаан буудайн гурил болон төмс, гол нэрийн хүнсний ногоогоор хэрэгцээгээ бүрэн хангах зорилго бүхий "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулсан болно.

#### Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

- 3.1. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах;
- 3.2. Орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглах;
- 3.3. Хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах;
- 3.4. Хөтөлбөрийг иргэд, аж ахуйн нэгжийн хүчээр хэрэгжүүлэх.

#### Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4. Тариалан эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амыг аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой ханган импортын хараат байдлыг арилгаж тариалангийн хөгжлийг эрчимжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

5. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилгуудыг дэвшүүлж байна:

- 5.1. Тариалан эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх;
- 5.2. Тариаланчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах;
- 5.3. Атаршсан талбайг эргэлтэд оруулах замаар тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;
- 5.4. Тариалангийн үндсэн тарималын үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх;
- 5.5. Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх.

#### Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6. Хөтөлбөрийн 5.1 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ:
  - 6.1. Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж стратегийн бүтээгдэхүүн болох буудайн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн цогц асуудлыг тусгах;

- 6.2. Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулж буудай тариалсан иргэн, аж ахуйн нэгжийн даатгалыг хураамжийн талаар төрөөс зохистой бодлого явуулах;

- 6.3. Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах техник, тоног төхөөрөмж, салбаз хэрэгсэл, услагдлын системийн тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоог гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төсөл боловсруулах;

- 6.4. Газар тариалангийн шинжлэх ухааны ололт, нээлтийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх судалгааны төсөл хэрэгжүүлэх;

- 6.5. Иргэн, аж ахуйн нэгжээс гурилын үйлдвэр, тариаланг дэмжих санд нийлүүлсэн дотоодын буудайнд тодорхой шагуурын дагуу Засгийн газраас урамшуулал олгох;

- 6.6. Тариаланг дэмжих сангийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлж, аж ахуй эрхлэх хэлбэрийг тодорхой болгох;

- 6.7. Тухайн жилийн ургацаас борлуулалтгүй үлдсэн буудайг аж ахуйн нэгжээс худалдан авч хадгалах оновчтой тогтолцоог зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн бий болгох;

- 6.8. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн банкны эзэлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх, хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтын банк байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

- 6.9. Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид хорших, нэгдэх, хувьцаат компани байгуулах замаар хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;

- 6.10. Спиртийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж шаардагдах түүхий эдийнхээ 50-иас доошгүй хувийг үйлдвэрлэдэг болгох;

7. Хөтөлбөрийн 5.2 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 7.1. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг мэргэжлийн удирдлага, арга зүйн дэмжлэгээр хангах, тариаланчид, механикжуулагчдыг давтан сургалтад хамруулах;

- 7.2. Мэргэжилтэй ажилчин бэлтгэх урт, богино хугацааны сургалт зохион байгуулах, тэднийг техник, тоног төхөөрөмж дээр дадлагажуулах;

- 7.3. Хөдөө аж ахуйн техникийн засварын инженер, үрийн агроном, хөрс болон ургамал хамгаалал, усалгаатай тариалангийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж үйлдвэрлэлд ажиллуулах;

- 7.4. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтэн, механикжуулагчдыг дэвшилтэт технологи нэвтрүүлж байгаа гадаад орнуудад зардлаар нь явуулж туршлага судлуулах;

- 7.5. Шинэ техник, технологи түршин нэвтрүүлэх, ажилчид сургах зорилготой үйлдвэрлэл-сургалтын байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлэх.

7.6. Тариалангийн үйлдвэрлэлийн менежментийг боловсронгуй болгох, аажуу эрхлэх чадавхийг сайжруулах.

8. Хөтөлбөрийн 5.3 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1. Атаршсан газраас ашиглах боломжтой талбайн хэмжээ, хөрсний үржил шимийн судалгааг мэргэжлийн байгууллагаар судлуулах;

8.2. Атаршсан газар болон хөрсний судалгааг үндэслэн нийт эргэлтийн талбайн хэмжээг 600.0 мянган га-гаас доошгүй болгох:

-2008 онд 50.0 мянган га;

-2009 онд 80.0 мянган га;

-2010 онд 100.0 мянган га атаршсан талбайг үйлдвэрлэлд ашиглах.

9. Хөтөлбөрийн 5.4 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1. Ганд тэсвэртэй, арвин ургацтай, усалгаатай болон усалгаагүй нөхцөлд тохирох зусах буудайн сортын үрийг 2008 онд 6000 тн, 2009 онд 5000 тн, 2010 онд 4000 тн импортлон үржүүлж, үрийн шинэчлэлийг түргэтгэх;

9.2. Үр үржүүлгийн төв байгуулж, таримлын сорт сорилт, үрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг төрөөс дэмжих;

9.3. Аж ахуйн нэгжийн үржүүлсэн, стандартад нийцсэн үрийг зах зээлийн жишиг үнээр улсын нөөц, тариаланг дэмжих санд худалдан авч дотоодод үрийн нөөц бүрдүүлэх;

9.4. Сэлгээнд зориулж хөх тариа, арвай, хошуу будаа, царгас, эрдэнэ шиш, вандуй зэрэг үр тариа, тэжээлийн ургамлын үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлэх;

9.5. Төмс, хүнсний ногооны нутагшсан сортын үр үржүүлэх.

10. Хөтөлбөрийн 5.5 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

10.1. Хөрсний үржил шимийг дээшлүүлэх, нэгжээс авах ургацгыг нэмэгдүүлэх зорилгоор биобордооны үйлдвэрлэлийг дэмжих, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх шинжлэх ухааны төсөл хэрэгжүүлэх;

10.2. Хөрсийг салхины элэгдэл, зөврэлээс хамгаалах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн техникийн 70-80 хувийг шинэчлэх;

10.3. Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн худалдаж авсан өндөр хүчин чадлын трактор, комбайн болон бордоо, ургамал хамгааллын бодис, усалтын системийн тоног төхөөрөмж худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судлах;

10.4. Засвар үйлчилгээний газрыг бий болгох, сэлбэгийн хангамжийг сайжруулах;

10.5. Өрхийн тариалан эрхлэгчдэд техникээр үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүд байгуулах;

10.6. Төлбөрт үйлчилгээ бүхий үр тариа цэвэрлэх байгууламж, нөөцлөх зориулалтын механикжсан агуулахыг бий болгох;

10.7. Тариалангийн талбайг хаших, ойн зурвас байгуулах, таримал ургамлыг өвчин, хортноос сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

10.8. Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 54.2 мянган га-д хүргэх;

10.9. Арван мянган га талбайг услах хүчин чадалтай усалтын хуучин системийг сэргээн засварлах, 22.0 мянган га талбай бүхий усалтын системийг шинээр ашиглалтад оруулах, 15 сая шоо метр усны нөөц бүхий усан санг байгуулах;

10.10. Хамгаалагдсан хөрсний тариалангийн талбайг нэмэгдүүлж дуслын усалгааг нэвтрүүлэх;

10.11. Зоорийн аж ахуйг хөгжүүлэхийг дэмжих;

10.12. "Тариалангийн салбарт баримтлах технологийн зөвлөмж"-ийг тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээр мөрдүүлж ажиллуулах;

10.13. Техник, технологийн шинэчлэл, усалтын системд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг жил бүр шалгах.

11. Төрийн захиргааны төв байгууллагууд дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

11.1. Хөтөлбөрийн 6.1-6.3 дахь заалтыг хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

11.2. Хөтөлбөрийн 6.5; 6.7-6.8; 9.2; 10.1; 10.3; 10.6; 10.8; 10.10-10.11 дэх заалтыг сангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

11.3. Хөтөлбөрийн 6.4 болон 7.1-7.5; 10.1 дэх заалтыг боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

11.4. Хөтөлбөрийн 8.1-8.3 дахь заалтыг байгаль орчны болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

11.5. Хөтөлбөрийн 7.4; 9.1; 10.5 дахь заалтыг гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх.

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага зохион байгуулалт, хяналт**

12. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг 2008-2010 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

13. Хөтөлбөрийг зохион байгуулах Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд ахлах бөгөөд орлогч дарга нь Хүнс, хөдөө аж ахуйн асуудал

эрхэлсэн сайд, бүрэлдэхүүнд нь сангийн, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, зарим аймгийн Засаг дарга, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллагын төлөөлөл орно.

14. Хөтөлбөрийг улсын хэмжээнд зохицуулах, мэргэжил арга зүйгээр удирдах үүргийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

15. Хөтөлбөр хэрэгжих аймаг, сумдад салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл орсон байна.

16. Хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөл, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батална.

17. Хөтөлбөрийн холбогдох заалтыг төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

18. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байна.

## Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

19. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

19.1. аж ахуйн нэгж, иргэдийн өөрийн хөрөнгө;

19.2. улсын төсөв;

19.3. орон нутгийн төсөв;

19.4. банкны зээл;

19.5. гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл;

19.6. дотоод, гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт;

20. Улсын төсвөөс гарах хөрөнгийг тухайн асуудлыг хариуцсан сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлнэ.

## Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

21. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

21.1. Хөтөлбөрт тусгагдсан эрх зүй, эдийн засгийн орчны хэрэгжилтийн үнэлгээ;

21.2. Мэргэжил эзэмшүүлсэн, урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан мэргэжилтэн, механикжуулагчийн тоо;

21.3. Нийт болон нэгж талбайгаас авсан ургацын хэмжээ;

21.4. Усалгаатай талбайн өсөлт, нэгж талбайн ургацын хэмжээ;

21.5. Хөдөө аж ахуйн техникийн шинэчилсэн тоо;

21.6. Тариалангийн салбарт шинээр бий болсон ажлын байрны тоо, өсөлт;

21.7. Гурил, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь.

22. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг үнэлэхдээ тухайн жилийн байгаль цаг уурын болон эдийн засгийн макро микро орчны байдал, зах зээлийн үнийн өсөлт зэргийг харгалзана.

Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд  
Орлогч дарга -Хүнс, хөдөө аж ахуйн сайд  
Гишүүд -Сангийн сайд  
-Байгаль орчны сайд;  
-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Сэлэнгэ аймгийн Засаг дарга,  
-Төв аймгийн Засаг дарга;

-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга;  
-Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга;  
-Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;  
-Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал;  
-Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал;  
-Тариаланг дэмжих сангийн гүйцэтгэх захирал;  
-Тариаланч, гурил үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);  
-Ургацын далай холбооны тэргүүн (тохиролцсоноор).  
Нарийн бичгийн дарга -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

### Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

нь:

1. "Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг бичил уурхайн үйл ажиллагаа болгон өөрчлөхөд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

### Дэд хөтөлбөр батлах тухай

3. "Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг жил бүр төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Х.НАРАНХҮҮ

Засгийн газрын 2008 оны 71 дүгээр тогтоолын хавсралт

### БИЧИЛ УУРХАЙГ 2015 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

#### Нэг. Оршил

1. Дэлхийн хэмжээнд эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт хэрэгцээ өсч, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрүүд нэмэгдэж, нөөцийн хэмжээ улам бүр хомсдож байгаа нөхцөлд ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах шаардлага тулгарч байна.

Ажилгүйчүүдийн тоо, ядуурлын түвшин орон нутагт мэдэгдэхүйц буурахгүй байгаагаас ашигт малтмалыг хувиараа олборлогчид олширч, эрдэс баялгийн нөөцийг үрэлгэн, үр ашиггүй ашиглаж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэж байна. Иймд хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах, албан хөдөлмөр эрхлүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Эрдэс баялгийн нөөцийн ашиглалтыг сайжруулахад нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, бичил уурхайг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ гарч байна.

#### Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго

2. "Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн зорилго нь:

2.1. Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн арга, бичил уурхайн хэлбэрээр ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохицуулах;

2.2. Уулын үйлдвэрийн ашигласан болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн үйлдвэрлэлийн бус агуулгатай нөөц, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн

засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон орд, илрэл дэх ашигт малтмалын нөөцийг бага оврын техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи хэрэглэн, осол аваарьгүй, эдийн засгийн үр ашигтайгаар олборлодог бичил уурхайн загварыг бий болгон үе шаттайгаар хөгжүүлэхэд оршино.

3. Энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтлана:

-хуулийг дээдлэх;

-орон нутгийн өөрөө удирдах ёсонд түшиглэх;

-иргэд, олон нийтийн үүсгэл санаачилга дээр тулгуурлах;

-экологийн тэнцвэрт байдлыг хадгалах.

**Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл**

4. Тэргүүлэх зорилт 1. Хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, улмаар уул уурхайн дэд салбар-бичил уурхайн загварыг бий болгох.

5. Тэргүүлэх зорилт 1-ийг үйл ажиллагааны дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

5.1. Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн арга, бичил уурхайн хэлбэрээр ашиглах эрх зүйн орчныг бий болгох;

5.2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, норм, нормативыг боловсруулж холбогдох байгууллагаар батлуулах;

5.3. Хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжүүлэх;

5.4. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ашигт малтмал олборлогч нөхөрлөл болон бичил уурхайг мэргэжлийн удирдлагаар хангах, энэ чиглэлээр мэдээллийн сантай болох;



5.5. Нөхөрлөлийн болон бичил уурхайн хэлбэрээр олборлож болох орд, илрэлийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээгээр гаргаж батлах;

5.6. Уул уурхайн дэд салбар-бичил уурхайг хөгжүүлэхтэй холбогдуулан аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг сургаж дадлагажуулах;

5.7. Бичил уурхайг геологи, уул уурхайн болон бусад мэргэжлийн инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдаар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, бичил уурхайн мэргэжлийн ажилчдыг сургах, давтан бэлтгэх;

5.8. Бичил уурхайгаас олборлосон үнэт металлыг худалдан авах журам боловсруулж хэрэгжүүлэх;

5.9. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалыг борлуулах төрөлжсөн биржийг бичил уурхай бүхий бус нутагт байгуулах асуудлыг судалж хэрэгжүүлэх;

5.10. Бичил уурхайгаас олборлосон эрдэс баялгийг хагас болон бүрэн боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг үзүүлэх.

6. Гарах үр дүн. Монгол Улсын хэмжээнд уул уурхайн дэд салбар-бичил уурхайн загвар бий болж, үйл ажиллагааны механизм бүрэлдэн тогтоно.

7. Тэргүүлэх зорилт 2. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн эдийн засгийн үр ашгитай үйл ажиллагааг бичил уурхай болгож, зохих техник, технологи хэрэглэхэд дэмжлэг үзүүлж, аюулгүй ажиллагааны шаардлага хангуулах.

8. Тэргүүлэх зорилт 2-ыг үйл ажиллагааны дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

8.1. Бичил уурхайгаар олборлох ашигт малтмалын илрэлд геологийн нэмэлт судалгаа хийх, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ хийх, ашиглалтын технологийн аргачилсан заавруудыг боловсруулах, сургалт зохион байгуулах;

8.2. Бичил уурхайнд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл үйлдвэрлэх, бага оврын техник нийлүүлэх аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих;

8.3. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг боловсруулж, мөрдүүлэх;

8.4. Томоохон уурхайнуудыг түшиглэн бичил уурхайн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн удирдлага, зөвлөлгөөгөөр хангах, аваар, ослоос урьдчилан сэргийлэх, аврах үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий хөдөлгөөнт багуудыг уул уурхайн аврах албаны харьяанд байгуулах ажлыг зохион байгуулах;

8.5. Алтны үндсэн орд, илрэлээс олборлосон хүдрийг боловсруулах жижиг үйлдвэрийг байгуулж үйл ажиллагаанд нь байнгын хяналт тавин ажиллуулах;

8.6. Бичил уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон нөхөн сэргээлт

хийх, түүнд хяналт тавих журам зэрэг баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх;

8.7. Бичил уурхайгаас олборлосон эрдэс баялгийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

8.8. Бичил уурхайг хөгжүүлэх туршилтын загвар бий болгож, ажлын ололт, туршлагыг нь түгээн дэлгэрүүлэх;

8.9. Гадаад орнуудын бичил уурхайн туршлагыг судалж нэвтрүүлэх.

9. Гарах үр дүн. Бичил уурхайн техник, технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны асуудал цогцоороо шийдвэрлэгдэж байгаль, нийгмийн өмнө хариуцлага хүлээх чадвартай уул уурхайн дэд салбар бий болно.

10. Тэргүүлэх зорилт 3. Нөхөрлөлийн зохион байгуулалттайгаар ашигт малтмал олборлогчид болон тэдний гэр бүлийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах.

11. Тэргүүлэх зорилт 3-ыг үйл ажиллагааны дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

11.1. Хувиараа ашигт малтмал олборлогчдыг бүртгэлжүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах;

11.2. Бичил уурхайд ажиллагсдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

11.3. Бичил уурхай эрхлэгчдийг мэргэжлээс шалтгаалах өвчний хяналтад оруулан үзлэг, үйлчилгээнд хамруулах;

11.4. Бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн үзлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явуулан үйлчилгээг бий болгон түүний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

11.5. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах, тогтвортой ажлын байр бий болгох чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг бичил уурхай эрхлэгчдийн гэр бүлд чиглүүлэх замаар хүүхэд, эмэгтэйчүүдийн оролцоог бууруулах;

11.6. Нөхөрлөлийн зохион байгуулалттайгаар ашигт малтмал олборлогчдын гэр бүлд орлогын хоёрдогч эх үүсвэр бий болгох чиглэлээр судалгаа хийсний үндсэн дээр холбогдох арга хэмжээг авч өрхийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах.

11.7. Насанд хүрээгүй хүүхэд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгааг зогсоож боловсролын үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авах;

11.8. Сургууль завсардсан хүүхэд, залуучуудыг албан бус болон зайны сургалтад хамруулан дунд боловсрол олгох арга хэмжээ авах.

12. Гарах үр дүн. Хувиараа ашигт малтмал олборлогчид албан ёсны ажлын байртай болж эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдан бус нутгийн хөгжлийн нэгэн хөдөлгөгч хүч болсон байна.



## Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

13. Дэд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны чиглэлийг дараахь үе шатаар хэрэгжүүлнэ:

13.1. I үе шат: (2008-2011 он)

13.1.1. бичил уурхай хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, уул уурхайн дэд салбар-бичил уурхайн загвар бий болгох;

13.1.2. хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад бүрэн шилжүүлэх;

13.1.3. бичил уурхайн үйл ажиллагааг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага зохицуулах, эдгээр байгууллагын эрх мэдлийн хүрээг өсгөх, орон нутагт ажлын байр шинээр бий болгох, ажилгүйчүүдийн тоо, ядуурлын түвшинг бууруулах;

13.1.4. том уурхайн зохион байгуулалтаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй ашигт малтмалын орд, илрэлийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар уул уурхайн нийт бүтээгдэхүүний 10 хувьтай тэнцэх хэмжээний бүтээгдэхүүнийг бичил уурхайгаар олборлодог болох;

13.1.5. бичил уурхайг мэргэжлийн инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдаар хангах, боловсон хүчний талаар бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхлэх;

13.1.6. бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон нийгмийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж, аюулгүй ажиллагааны сургалт, хяналт, шалгалтын зөв тогтолцоог бүрдүүлэх.

13.2. II үе шат: (2012-2015 он)

13.2.1. дэвшилтэт технологи, менежмент бүхий бичил уурхайн үйлдвэрлэл, технологийн паркийн үйлчилгээг нэмэгдүүлж, I үе шатанд үндэс суурь нь тавигдсан бичил уурхайн үйл ажиллагаа жигдрэхийн эсрэгцээ орлогын хоёрдогч эх үүсвэрийг бий болгон хөгжүүлэх;

13.2.2. бичил уурхайд тохирсон тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, нийлүүлдэг сүлжээг шинээр бий болгох;

13.2.3. бичил уурхайгаас олборлосон бүтээгдэхүүнийг борлуулах бирж, зах зээлийн сүлжээ бий болгох.

## Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага

14. "Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үүргийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцаж геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

15. Дэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд дэмжлэг үзүүлнэ.

16. Дэд хөтөлбөрийг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулж хэрэгжүүлнэ.

17. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн бул байгууллага, олон улсын байгууллага, хандивлагч орон, геологи, уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг компани, нөхөрлөл, бичил уурхай хамтран оролцоно.

## Зургаа. Дэд хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр

18. "Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг дараахь эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

18.1. Улсын болон орон нутгийн төсөө;

18.2. Ашигт малтмалын нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн тогтоосон хувь;

18.3. Гадаад орон, олон улсын байгууллагын тусламж.

19. Бичил уурхай байгуулахтай холбогдсон зардлыг сонирхогч нөхөрлөл, хоршоо, компани өөрөө санхүүжүүлнэ.

## Долоо. Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

20. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

20.1. Эрх зүйн орчин бүрдсэн эсэх, түүний хэрэгжилтэд хөндлөнгийн шинжээчийн өгсөн үнэлгээ;

20.2. Мэргэжлийн боловсон хүчний хангамж 2011 онд 40 хувь, 2015 онд 75 хувь хүрсэн байх;

20.3. Бичил уурхайгаас олборлосон ашигт малтмалын хэмжээ 2011 онд хувиараа ашигт малтмал олборлогчдын олборлосны 60 хувьд, 2015 онд 95 хувьд хүрсэн байх;

20.4. Ашигт малтмал олборлох технологийн горим 2011 онд хувиараа ашигт малтмал олборлогчдын 60 хувьд, 2015 онд 95 хувьд хүрсэн байх;

20.5. Үйлдвэрлэлийн ослын тоо 2007 онтой харьцуулбал 2011 онд 50 хувиар, 2015 онд 75 хувиар тус тус буурсан байх;

20.6. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хэмжээ 2011 онд 30 хувьд, 2015 онд 80 хувьд хүрсэн байх;

20.7. Тухайн нутагт ажилгүйдлын түвшин 4 хувиас бага байх;

20.8. Тухайн орон нутагт ядуурлын түвшинг 2007 оныхоос 2011 онд 30 хувь, 2015 онд 2 дахин бууруулсан байх;

20.9. 2011 онд нөхөрлөлийн гишүүдийн 80 хувь, 2015 онд 100 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байх;

20.10. Тухайн орон нутагт мэргэжлээс шалтгаалах болон халдварт өвчин 2007 оныхоос 2011 онд 50 хувь, 2015 онд 65 хувиар буурсан байх;

20.11. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтийг 2015 онд зогсоосон байх;

20.12. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2011 онд хувиараа ашигт малтмал эрхлэгчдийн хүүхдийн 60 хувь, 2015 онд 75 хувь хамрагдсан байх.